



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Хяналтын дагалдах хуудасны маягт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/752 дугаар захирамжаар батлагдсан нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд ашиглагдах хяналтын дагалдах хуудасны маягтыг хавсралтаар баталсугай.
2. Захиргааны шийдвэр бүрд хяналтын дагалдах хуудас хавсаргах, дагалдах хуудсанд захиргааны шийдвэр боловсруулахад оролцсон албан хаагч бүрийн оролцсон оролцоо, гүйцэтгэлийг тэмдэглэх ажиллагааг тухай бүрд нь хийж гүйцэтгэхийг Захиргаа удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б. Сэргэлэн/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг орлогч нарт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БОЛОРМАА

Нийслэлийн худалдан авах
 ажиллагааны газрын даргын албан
 үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2016
 оны 10 дугаар сарын 28 ны өдрийн
 1119 дугаар тушаалын хавсралт



ХЯНАЛТЫН ДАГАЛДАХ ХУУДАСНЫ МАЯГТ

ЗАХИРГААНЫ ШИЙДВЭРИЙН НЭР:

ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ

АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСЛЭЛ:

ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ

АЖИЛЛАГААНЫ ҮЕ ШАТ:

Огноо	Захиргааны шийдвэр боловсруулахад оролцсон албан хаагчдын овог нэр	Албан тушаал	Оролцоо	Гүйцэтгэл	Гарын үсэг
	1	2	3	4	5